

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөөгийн шийдэл ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/010/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Мөрөн сум
2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Б.Ариунтуяа
Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: Munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 01/291
танай _____-ны № _____-т

“ХӨДӨӨГИЙН ШИЙДЭЛ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.АМАРБАЯСАХ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл аймгийн “Хөдөөгийн шийдэл” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Хөдөөгийн шийдэл” ХХК-ийн үндсэн хөрөнгийн дансанд улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн газар тариалан, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэдийг дэмжиж, тэдэнд түрээсээр худалдан борлуулах зориулалт бүхий 6,350,230.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 782,057.7 мянган төгрөгийн мал бүртгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

“Хөдөөгийн шийдэл” ХХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 2,887,637.9 мянган төгрөгийн 15 алдаа, зөрчлийг илрүүлж 2,854,854.9 мянган төгрөгийн 7 алдааг аудитын хугацаанд залруулж, 32,783.0 төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

“Хөдөөгийн шийдэл” ХХК нь тайлант жилд батлагдсан орлогын төлөвлөгөөг 13.5 хувиар давуулж биелүүлсэн ба зардлын гүйцэтгэл 86.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А. ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөр	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	35,831,326.94	356,123,909.84
1.1.2	Дансны авлага	46,199,610.00	423,791,288.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	0.00	322,025.33
1.1.6	Бараа материал	13,550,802.00	75,201,900.00
1.1.9	Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	195,159,000.00	6,350,229,959.93
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	290,740,738.94	7,205,669,083.10
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,935,661,233.33	479,191,736.07
1.2.2	Биет бус хөрөнгө	381,000.00	161,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө	782,057,700.00	782,057,700.00
1.2.9	Бусад биет бус хөрөнгө	31,047,000.00	31,047,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,749,146,933.33	1,292,457,436.07
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,039,887,672.27	8,498,126,519.17
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР	9,658,749.86	56,012,498.05
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	9,658,749.86	56,012,498.05
2.1.1.3	Татварын өр	9,658,749.86	56,012,498.05
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,658,749.86	56,012,498.05
2.2	Өр төлбөрийн нийт дүн	9,658,749.86	56,012,498.05
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	429,555,000.00	429,555,000.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	3,347,366,200.00	7,068,575,200.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	253,307,722.41	943,983,821.12
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	4,030,228,922.41	8,442,114,021.12
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	4,039,887,672.27	8,498,126,519.17

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	/төгрөгөөр/ Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	210,060,833.52	982,101,498.63
3	Нийт ашиг (алдагдал)	210,060,833.52	982,101,498.63
10	Ерөнхий ба удирдлагын зардал	315,262,239.44	456,517,584.82
12	Бусад зардал	450,000.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	4,566,000.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(105,651,405.92)	530,149,913.81
19	Орлогын татварын зардал	0.00	53,095,815.10
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(105,651,405.92)	477,054,098.71
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(105,651,405.92)	477,054,098.71
24	Орлогын нийт дүн	(105,651,405.92)	477,054,098.71
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	/төгрөгөөр/
				НИЙТ ДҮН
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	429,555,000.00	3,171,682,200.00	358,959,128.33	3,960,196,328.33
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	(105,651,405.92)	(105,651,405.92)
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	175,684,000.00	0.00	175,684,000.00
2024 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	429,555,000.00	3,347,366,200.00	253,307,722.41	4,030,228,922.41
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	213,622,000.00	0.00
Залруулсан үлдэгдэл	429,555,000.00	3,347,366,200.00	466,929,722.41	7,965,059,922.41
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	477,054,098.71	477,054,098.71
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	3,721,209,000.00	0.00	0.00
2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	429,555,000.00	7,068,575,200.00	943,983,821.12	8,442,114,021.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	/төгрөгөөр/
			Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	228,032,793.52	822,398,120.63
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	180,551,140.00	811,997,074.80
	Татаас, санхүүжилтын орлого	30,000,000.00	0.00
	Бусад мөнгөн орлого	17,481,653.52	10,401,045.83
1.2	Мөнгөн зарлага (-)	268,252,286.78	469,305,537.73
	Ажиллагчдад төлсөн	125,690,594.00	205,142,513.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	36,343,259.96	56,820,857.01
	Бараа материал худалдан авахад төлсөн	39,601,591.44	111,861,173.00
	Ашиглалтын зардалд төлсөн	30,206,198.71	35,423,570.86
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	24,345,891.00	26,887,629.92
	Хүүний төлбөрт төлсөн	0.00	63,251.06
	Татварын байгууллагад төлсөн	11,903,158.12	24,563,319.98
	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	89,100.00
	Бусад мөнгөн зарлага	161,593.55	8,454,122.90
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(40,219,493.26)	350,092,582.90
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	32,800,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	32,800,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	(32,800,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(40,219,493.26)	320,292,582.90
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	76,750,820.20	35,831,326.94
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	35,831,326.94	356,123,909.84

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх оны үзүүлэлт	2025 он			
				Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Биелэлт
1	Нийт орлого	мян. төг	210,060.9	869,531.6	986,667.5	-117,135.9	113.5
	Хөрөнгийн эргэн төлөлтийн орлого	мян. төг	119,682.0	774,591.6	950,881.3	-176,289.7	122.8
2	Нийт үйл ажиллагааны орлого	мян. төг	90,378.9	94,940.0	35,786.2	59,153.8	37.7
	Хүнсний ногооны, тракторын орлого	мян. төг	22,300.0	25,500.0	13,885.4	11,614.6	54.5
	Ногоон тэжээлийн орлого	мян. төг	20,597.2	35,000.0	13,095.6	21,904.4	37.4
	Бусад орлого	мян. төг	47,481.7	34,440.0	8,805.2	25,634.8	0.0
3	Нийт үйл ажиллагааны зардал	мян. төг	314,259.5	528,470.7	456,517.3	71,953.4	86.4
1	Нийт цалингийн сан	мян. төг	129,349	236,834.8	221,816.6	15,018.2	93.7
2	ТУЗ-ийн зардал	мян. төг	16,820.0	38,400.0	18,849.1	19,550.9	49.1
3	Татварын зардал	мян. төг	0.0	0.0	0.0	0.0	0.0
4	НД-ын шимтгэл	мян. төг	21,051.9	34,026.9	34,453.0	-426.1	101.3
5	Тракторын шатахууны зардал	мян. төг	13,584.0	21,600.0	16,000.0	5,600.0	74.1
6	Хүлэмжийн аж ахуйн зардал	мян. төг	0.0	33,806.0	8,030.9	25,775.1	23.8
7	Бичиг хэрэг, оффисын зардал	мян. төг	4,245.0	4,800.0	3,584.7	1,215.3	74.7
8	Интернет, утасны зардал	мян. төг	892.3	3,600.0	1,273.8	2,326.2	35.4
9	Бизнес хөгжлийн төвийн бохир усны зардал	мян. төг	0.0	2,400.0	0.0	2,400.0	0.0
10	Дулааны зардал	мян. төг	39,903.3	24,275.0	37,395.2	-13,120.2	154.0
11	Хог хаягдлын зардал	мян. төг	240.0	2,000.0	1,200.0	800.0	60.0
12	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	мян. төг	2,585.8	3,600.0	3,465.0	135.0	96.3
13	Шатахууны зардал	мян. төг	10,810.0	12,000.0	10,200.0	1,800.0	85.0
14	Томилолтын зардал	мян. төг	3,209.8	9,600.0	7,115.0	2,485.0	74.1
15	Засвар үйлчилгээний зардал	мян. төг	9,072.9	10,000.0	9,261.0	739.0	92.6
16	Аудитын Төлбөр	мян. төг	3,000.0	4,000.0	3,000.0	1,000.0	75.0
17	Газрын төлбөр	мян. төг	496.8	1,000.0	496.7	503.3	49.7
18	Тээврийн хэрэгслийн оношилгоо	мян. төг	0.0	143.0	0.0	143.0	0.0
19	Тээврийн хэрэгслийн татвар	мян. төг	0.0	165.0	480.0	-315.0	290.9
20	Даатгалын үйлчилгээ	мян. төг	0.0	420.0	89.1	330.9	21.2
21	Контейнер	мян. төг	0.0	15,000.0	0.0	15,000.0	0.0
22	Нэг удаагийн тэтгэвэр тэтгэмж	мян. төг	450.0	2,000.0	3,140.0	-1,140.0	157.0
23	Хөдөлмөр хамгааллын зардал	мян. төг	2,346.6	2,400.0	2,400.0	0.0	100.0
24	Сургалтын зардал	мян. төг	1,135.7	2,000.0	1,720.0	280.0	86.0
25	Зар сурталчилгааны зардал	мян. төг	1,704.0	1,200.0	688.7	511.3	57.4
26	Бусад үйл ажиллагааны зардал	мян. төг	0.0	35,000.0	0.0	35,000.0	0.0
27	Тээврийн зардал	мян. төг	3,300.0	5,000.0	5,000.0	0.0	100.0
28	Урсгал засварын зардал	мян. төг	0.0	10,000.0	2,261.0	7,739.0	22.6
29	Агуулах түрээс	мян. төг	6,800.0	13,200.0	9,000.0	4,200.0	68.2
30	Элэгдлийн зардал	мян. төг	43,262.5	0.0	55,597.5	-55,597.5	0.0
4	Татварын өмнөх ашиг/ алдагдал	мян. төг	-104,198.6	341,060.9	530,150.2	-189,089.3	155.4
1	Татварын зардал	мян. төг	0.0	34,106.1	53,095.8	-18,989.7	155.7
5	Татварын дараах ашиг	мян. төг	0.0	306,954.8	477,054.4	-170,099.6	155.4

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,854,854.9 мянган төгрөгийн 7 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

1. Тайлант онд шинээр ашиглалтад орсон 19,800.0 мянган төгрөгийн худгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх;” байх заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул бараа материалын данснаас хасаж, үндсэн хөрөнгийн дансанд бүртгүүлж, залруулсан.
2. Мөнгөн гүйлгээний тайланг 3,938.5 мянган төгрөгөөр зөрүүтэй бэлтгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх;” байх заалттай нийцэхгүй, “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул залруулж, зөрүүг арилгасан.
3. НДШ-ийн өглөгийг 950.4 мянган төгрөгөөр ХХОАТ-ын өглөгийг 322.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх;” байх заалттай нийцэхгүй, “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул залруулж, өглөгийг бүрэн тусгасан.
4. Цалингийн 900.0 мянган төгрөгийн урьдчилгааг авлагаар бүртгээгүй орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх;” байх заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул авлагаар бүртгэж залруулсан.
5. Иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээгээр тоног төхөөрөмж болон хүлэмж, малын эргэн төлөлтөөс авах авлагыг өмнөх онуудад 213,622.0 мянган төгрөгөөр, тайлант онд 166,775.7 мянган төгрөгийг дутуу тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.” заалт, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дэх “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;”-ыг заавал бүртгэх заалтыг хэрэгжүүлээгүй, 5 дугаар зүйлийн 5.1.3 дэх “жинхэнэ хэрэгжилтийн” зарчмыг мөрдөөгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул залруулга хийж, авлагыг тусгасан.
6. Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа трактор, тоног төхөөрөмжийн 14,684.3 мянган төгрөгийн элэгдлийг байгуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “үнэн зөв байх;” байх заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул залруулга хийж, элэгдлийг нөхөж байгуулан, нягтлан бодох бүртгэлд тусгасан.
7. Өмнөх жилүүдэд үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан 2,433,862.0 мянган төгрөгийн борлуулах зориулалттай тоног төхөөрөмж, хөрөнгө нь НББОУС-16 “Үндсэн хөрөнгө”-д заасан шалгуурыг хангахгүй “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул борлуулахаар эзэмшиж буй хөрөнгийн дүнг нэмэгдүүлж, үндсэн хөрөнгийн дүнг бууруулсан залруулга хийсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 32,783.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 45,448.7 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 32,783.0 мянган төгрөгийн зөрчил² илрүүлснээс санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн 32,783.0 мянган төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж, нийцлийн аудитаар илрүүлсэн зөрчилд 2 зөвлөмжийг өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус компанийн нягтлан бодох бүртгэлд ашиглаж байгаа Лидер программ нь байгууллагын үйл ажиллагааны онцлогтой уялдахгүй, зээлийн эргэн төлөлт, хүү, алдангийн тооцоолол хийх, авлагын насжилт тооцох боломжгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг нэвтрүүлэх

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ТУЗ-ийн аудитын хороо, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон гүйцэтгэх удирдлагын зүгээс дотоод хяналтыг зохион байгуулж, хэрэгжүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно.” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТУЗ-ын зүгээс болон байгууллагын дотоодод хяналт хэрэгжүүлэх төлөвлөгөөг гаргаж, биелэлтийг тооцож ажиллах

3. Гэрээний биелэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шинэ хөдөө төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа жижиг, дунд аж ахуй эрхлэгчдийг дэмжих зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэй олгож байгаа тоног төхөөрөмжийн гэрээнд заасан хугацаа хэтэрсэн алдангийг тооцож нэхэмжлээгүй, он дамжсан эргэн төлөлтийн авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй, бүрэн төлөлт хийгдсэн тоног төхөөрөмжийн гэрээг дүгнэж иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшилд шилжүүлж, компанийн данс бүртгэлээс хасаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 заалтад “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэж заасантай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж:

Төлөлт нь бүрэн хийгдсэн хөрөнгийг эзэмшигчид хүлээлгэн өгөх, данс бүртгэлээс хасах талаарх шийдвэрийг эрх бүхий байгууллагаар гаргуулж шийдвэрлүүлэх, удаан хугацаанд барагдахгүй байгаа авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, гэрээнд заасны дагуу алдангийг тооцож нэхэмжлэх

4. Барьцаа хөрөнгийн гэрээтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аймгийн ИТХ-ын 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 58 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Хөдөөгийн шийдэл ОНӨХХК-ийн хөрөнгийг удирдах, зөвлөн туслах, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1 заалтад “Хөдөөгийн шийдэл ОНӨХХК нь шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгжтэй зээлийн болон барьцааны гэрээг байгуулж хөрөнгийг олгоно” гэж заасан байхад барьцаа хөрөнгийн гэрээ байгуулж, нотариатаар батлуулж хавсаргаагүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

“Хөдөөгийн шийдэл ОНӨХХК-ийн хөрөнгийг удирдах, зөвлөн туслах, төсөл сонгон шалгаруулах журам”-д заасныг хэрэгжүүлж барьцааны гэрээг хийж, нотариатаар батлуулан гэрээнд хавсаргах.

5. Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулахтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тоног төхөөрөмжийг хадгалах агуулах сав, саравч хангалтгүй, ил задгай хадгалж байгаагаас иргэн аж ахуйн нэгжид олгогдоогүй байгаа тоног төхөөрөмжийн чанар байдал муудах, зэврэх, элэгдэлд орох, цаашид ашиглах боломжгүй болох, хөрөнгө шамшигдах эрсдэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, чанар байдлыг дордуулахгүй байхад анхаарч ажиллах

6. Найдваргүй авлагын болон эргэлтийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хөдөөгийн шийдэл ХХК нь иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээний үндсэн дээр эргэн төлөгдөх нөхцөлөөр буюу зээлийн борлуулалт хийдэг онцлогтойгоо уялдуулсан найдваргүй авлагын сан бүрдүүлээгүй, зээлийн эргэн төлөлтөөс эргэлтийн сан бүрдүүлж төслийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Найдваргүй авлагын сан, эргэлтийн сан байгуулах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулж, шийдвэр гаргуулах, мөрдөж ажиллах.

7. Албан татвар ногдох орлогоос хасагдах зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант жилд 15 иргэнээс 32,783.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авч, төлбөрийг э-баримтаар баталгаажуулаагүй шилжүүлсэн байгаа нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 “доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Хувь иргэн, аж ахуйн нэгжид бараа, ажил үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхдээ э-баримтаар баталгаажуулж байх.

8. Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам, тайлангийн маягт, аргачлал батлах тухай" журмын дагуу санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланг бэлтгээгүй байгаа нь “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тайлангуудын үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланг бэлтгэж хэвших

9. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хөдөөгийн шийдэл ХХК нь төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим хуудсанд тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оруулж батлуулаагүй, тайлагнаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдаж авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 заалтад “Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn цахим хуудсаар илгээж батлуулах, гүйцэтгэлийг тайлагнах

10. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд 6 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан

байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:”, 6.4 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд байршуулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор оруулж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн
Завсрын аудитаар:										
Цалин, урьдчилгаатай холбоотой	6	19,742.1			6	19,742.1	6	19,742.1		
Жилийн эцсийн аудитаар:										
Худгийг бараа материалын дансанд орлогод авсан	1	19,800.0			1	19,800.0	1	19,800.0		
Мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй бэлтгэсэн	1	3,938.5			1	3,938.5	1	3,938.5		
Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу байгуулсан	1	14,684.3			1	14,684.3	1	14,684.3		
НДШ, ХХОАТ-ын өглөгийг зөрүүтэй тусгасан	1	1,272.4			1	1,272.4	1	1,272.4		
Цалингийн урьдчилгааг авлагад тусгаагүй	1	900.0			1	900.0	1	900.0		
Тайлант жилд гэрээний дагуу төлөгдөх дүнгээр авлага үүсгэж орлогыг бүрэн бүртгээгүй	1	380,397.7			1	376,682.7	1	376,682.7		
Борлуулах зориулалтай тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн	1	2,433,862.0			1	2,433,862.0	1	2,433,862.0		
Дүн	7	2,854,854.9			7	2,854,854.9	7	2,854,854.9		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн программ шаардлага хангахгүй байна	1	-					1	-
Дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй	1	-					1	-
Гэрээний алдангийг тооцоогүй, эргэн төлөлтөө хийсэн иргэн аж ахуйн нэгжийн гэрээг дүгнэж, данснаас хасаагүй	1	-					1	-
Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан бэлтгээгүй	1	-					1	-
Борлуулах зориулалттай хөрөнгийн хадгалалт хамгаалалт хангалтгүй	1	-					1	-
Найдваргүй авлагын сан, эргэлтийн сан байгуулаагүй	1	-					1	-
Барьцаа хөрөнгийн гэрээ байгуулаагүй	1	-					1	-
Хувь хүний данс уруу шилжсэн мөнгийг э-баримтаар баталгаажуулаагүй	1	32,783.0					1	32,783.0
Дүн	8	32,783.0					8	32,783.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Шилэн дансны цахим хуудсанд 6 төрлийн мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn цахим хуудсаар илгээж батлуулаагүй, тайлагнаагүй	1	-					1	-
Дүн	2	-					2	-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨХХК	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:
Б.АРИУНТУЯА ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Б.МЯДАГМАА ОГНОО:

ГҮЙЦЭТГЭСЭН:
ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.МӨНХТУЯА ОГНОО:



Handwritten signature/initials